

БАТЛАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх газар, нэгжүүд
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	2018	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх		ЗУГ, МТХ
2		Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн	2018	Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх		ЗУГ, МТХ

		нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох				
3	4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2018	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх		Бүх газар, нэгжүүд
4	4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	2018	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх		Бүх газар, нэгжүүд ДХХ Ёс зүйн хороо
5	4.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	2018	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байх		Бүх газар, нэгжүүд МТХ
6	4.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах	2018	Нийтийн албаны сургалтын институтыг байгуулсан байх		Бүх газар, нэгжүүд МТХ

7		Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах	2018	Модуль, хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулсан байх	Бүх газар, нэгжүүд МТХ
8		Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	2018	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувийг сургалтад хамруулсан байх	Бүх газар, нэгжүүд МТХ
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
9	4.1.2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	2018	Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчилсэн байх	Бүх газар, нэгжүүд МТХ
10		Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2018	Төрийн үйлчилгээний нэгдсэн үйлчилгээний портал сайтыг боловсронгуй болгосон байх	Бүх газар, нэгжүүд МТХ
11	4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2018	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг болсон байх	Бүх газар, нэгжүүд ХШЗГ

	зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох				
12	4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	2018	Хөндлөнгийн байгууллагаар жил тутамд үнэлгээ хийлгэсэн байх	Бүх газар, нэгжүүд
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
13	4.1.3.3.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод хяналттай болгох	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	2018	Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх	Бүх газар нэгжүүд, МТХ
14	4.1.3.5.Санхүүгийн байгууллагын санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгож, давуу байдлаа ашиглан иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох	Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээ авах	2018	Зээлийн хугацаа, зээлийн хүүгийн таатай нөхцөл бүрдсэн байх	ББСБГ, ҮЦГ, СЭШХ
15		Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох	2018	Зээл олгох үйлчилгээний шимтгэлийг бодитой тогтоосон байх	ББСБГ, ҮЦГ, СЭШХ

16		Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах	2018	Хуулийн хэрэгжилт сайжирсан байх		ББСБГ, ҮЦГ, СЭШХ
17		Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээ авах	2018	Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх бодитой арга хэмжээ авсан байх		ҮЦГ, СЭШХ
18	4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2018	Хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлсэн байна		Бүх газар, нэгжүүд ХШЗГ, СХОА
19	4.1.3.8.аудитын үйл ажиллагааг хараат бус, хуулийн дагуу гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, шаардлагатай зарим тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах эрх зүйн орчинг бий болгох	Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах	2018	Аудитын байгууллагын талаар олон нийтэд хүртээмжтэй мэдээлдэг болсон байх		Бүх газар, нэгжүүд
Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр						
20	4.1.5.4. Авлига албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэлд дүгнэлт хийх тогтолцоог	Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор	2018	Санхүүгийн хариуцлага сайжирсан байх		Бүх газар, нэгжүүд ХШЗГ, ЗУГ

	бүрдүүлэх, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх /Real name financial Transaction act/ эрх зүйн орчин бий болгох				
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр						
21	4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	2018	Эрх зүйн зохицуулалт бий болгосон байх		Бүх газар, нэгжүүд
Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
22	4.1.10.1 авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	2018	Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх		Бүх газар, нэгжүүд ЗУГ

2018-02-15